МОНГОЛ ОЮУТНЫ ГАДААД ХЭЛЭЭР ЯРИХ ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ НЬ

Л.ЗОЛЖАРГАЛ

Судалгааны ажлын ерөнхий үндэслэл

- Монгол улсад япон хэл зааж эхлээд 40 жилийн нүүр үзэж байгаа боловч монгол хүнд зориулсан англи, орос зэрэг гадаад хэлний заах аргатай харьцуулахад бага судлагдсан гэж хэлж болно. Япон хэлний заах аргын асуудлууд сүүлийн үед нэлээд эрчимтэй судлагдаж байгаа бөгөөд энэ нь япон хэлний сургалт 1990-ээд оноос эрчимжиж, япон хэл заах арга, Монгол дахь гадаад хэл заах аргын бие даасан чиглэл болж ирсэнтэй холбоотой юм.

Судалгааны ажлын ерөнхий үндэслэл

- Нөгөөтэйгүүр монгол хүний тухайд япон хэлийг сурч эзэмшихэд дөхөмтэй хийгээд хүндрэлтэй хоёр тал бий бөгөөд сургах хийгээд суралцахад бэрхшээл учруулдаг тулгамдсан асуудлуудын язгуур үндсийг нь олж судлах шаардлагатай байна. Япон, монгол хэл нь адилхан Алтай язгуурын хэлний ангилалд багтдаг гэдэг утгаараа хэл зүйн хувьд нийтлэг дөхөмтэй тал байдаг ч хүндрэлтэй тал нь гэвэл тухайн хоёр ард түмний соёлын ялгаа хэлний түвшин ахих тусам бэрхшээл учруулдаг явдал юм. Дунд түвшин хүртэл монгол оюутнууд унших, бичих, сонсох чадварын хувьд бусад орны суралцагсдаас харьцангуй амжилттай суралцдаг хэдий ч ярианы чадварын хувьд хоцрогдож эхэлдэг. Үүнийг япон хэл заах арга эсвэл хэлний бус орчинд суралцаж байгаатай холбон тайлбарлах нь түгээмэл боловч N3 буюу япон хэлний дунд түвшинд монгол оюутны ярих чадварыг сайжруулах асуудлыг боловсролын сэтгэл судлал-зэрэгцүүлсэн хэл шинжлэл-хэлний соёл судлалын гурамсан холбоонд авч үзэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа нь судалгааны ажлын гол үндэслэл болсон юм.

Сэдвийн судлагдсан байдал

Гадаадын эрдэмтэд

- Horwitz E.K — Using student beliefs about language learning and teaching in the foreign language methods course.
- Леонтьев А.А — Хэл гэж юу вэ
- Дуглас Браун — Хэл сурах сургах зарчим
- Abe Shin — Хэл сурах итгэл үнэмшлийн олон талт шинжилгээ

Монголын эрдэмтэд

- Нямжав.Д — Сэтгэц хэл шинжлэл
- Мира Н — Суралцах арга барилын технологийн шинэчлэл
- Хишигдэлгэр.Б — Гадаад хэлний сургалтын арга, онол ба хэрэглээ

Судалгааны ажлын зорилго

Хэлний бус орчинд, япон хэлний дунд (JLPT-N3) түвшинд мэргэжлийн ангийн монгол оюутны япон хэлээр ярих чадварыг сайжруулах боломжийг судлан, нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлоход ажлын гол зорилго оршино.

Зорилт

1. Гадаад хэлээр ярих чадвар эзэмшүүлэх сургалтын хэл шинжлэл, сэтгэл судлалын үндэслэл, онцлогийн талаар, онол, судалгааны бүтээлүүдтэй танилцах
2. Монгол оюутны япон хэлээр ярих чадварт нөлөөлж буй сэтгэл зүйн болон хэл шинжлэл, хэлний соёл судлал, япон хэл заах аргын хүчин зүйлүүдийг судлан тодруулах
3. Хэлний бус орчинд суралцаж буй монгол оюутнуудын япон хэлээр ярих чадварыг монгол хэлний чадвартай харьцуулан дүн шинжилгээ хийх
4. Их дээд сургуульд япон хэлээр ярих чадвар эзэмшүүлж буй хөтөлбөрийн ярих чадвар олгох агуулгад задлан шинжилгээ хийх
5. Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэх

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн

Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: **ГАДААД ХЭЛЭЭР ЯРИХ ЧАДВАР ЭЗЭМШҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ҮНДЭС**

Хэл ярианы чадварын сэтгэл зүйн үндэс

Ярих чадвар эзэмшүүлэх орчин үеийн заах аргын чиг хандлага

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал	Смарт боловсрол	Суралцахуйн онол

Монгол оюутанд гадаад хэлээр ярих чадвар эзэмшүүлэх түгээмэл аргууд

Даяаршлын үеийн боловсрол нь :

- мэдлэг эзэмшиж сурах
- хөдөлмөрлөж сурах
- **амьдарч сурах**

Даяаршлын үеийн боловсролын агуулга :

- мэдлэг эзэмшүүлэх
- хөдөлмөрийн чадвар дадал олгох
- **сэтгэлгээ,харилцаа хандлага төлөвшүүлэх**

Даяаршлын үеийн боловсролоор эзэмших чадвар :

- суурь чадвар /унших,бичих../
- мэргэжлийн чадвар/аль нэг салбарт ажиллах /
- **Нийгмийн чадвар/ нийгэмтэй зохицон амьдрах /**

ярих чадвар
УНШИХ :
1. үгийн сан нэмэгдэнэ
2. хэлний нийлмэл бүтцүүд хоршоо үг,холбоо үг,хэлц хэллэгүүд тэр хэлбэрээрээ тогтоогдоно
3. анхан шатны түвшинд чанга дуугаар давтан уншлага хийлгэх нь сонсох чадварыг хөгжүүлнэ.
БИЧИХ :
1.бичгийн хэлний бүтцээр цэгцтэй,логикто й ярьж сурах дадлага 2. найруулгын төрөл зүйлүүдийн ялгааг
3.бичгийн ба ярианы хэлний ялгааг ойлгож
СОНСОХ :
1.ярих чадварын 50% нь сонсож ойлгох чадвартай холбоотой
2. сонсоод ойлгох төдийгүй мэдээллийн боловсруулалт хийж байдаг онцлогтой
3. харилцагчийн ярианы хурд,онцлогийн
дасна.
ОРЧУУЛАХ :
1.хэлний бусад чадваруудын үр дүн дээр суурилна
2. аман орчуулгын явцад ярих чадвар
хөгжинө.
3.сэтгэлгээ,танин мэдэхүйн түвшингээс хамааралтай

Монгол оюутанд гадаад хэлээр ярих чадвар эзэмшүүлж буй түгээмэл аргууд

- Бэлтгэлгүй яриулах
- Уншаад ярих
- Театрчилсан тоглолт
- Бичлэг сонсоод ярих
- Дуу ба тоглоомын арга
- Калланы арга
- Зураг дүрслэлийн арга
- Багаар ажиллуулах
- Сурах бичгийг оновчтой ашиглах
- Кино хичээл

- Монгол улсад хамгийн өргөн хүрээнд явагдаж байгаа англи хэлний сургалтын жишээнд гадаад хэлний ярианы хичээлд хэрэглэгдэж буй түгээмэл аргууд хийгээд ярианы хичээлд анхаарах зүйлийн талаар англи хэлний багш, судлаачдын бүтээлд тулгуурлан авч үзэхэд сургалтын аргын хувьд багшийн онцлогоос хамаарч янз бүрийн аргуудыг хэрэглэж байна. Дээр дурдсан аргууд нь ерөнхийдөө бусад гадаад хэлний сургалтанд ч нэгэн адил хэрэглэгдэж байгаа нь судалгаанаас харагдаж байгаа юм. Заах арга талаас нь харвал оюутнуудын сэтгэлзүйн онцлогийг харгалзсан тал дутмаг байгаа нь анхаарал татаж байна. Харин сайшаалтай нь ярианы хичээлд анхаарах зүйл нь ихэвчлэн сэтгэлзүйн хүчин зүйлтэй холбогдож байгаа нь багш нарын судалгаа эрэл хайгуул зохих үр дүнд хүрч, гадаад хэл заах аргыг “суралцахуй төвтэй“ авч үзэх хандлага хүрээгээ тэлж байгааг харуулж байна.

- Азийн хэлүүдээс сүүлийн жилүүдэд идэвхжиж буй хятад хэлний сургалтын тухайд, хятад хэлний багш, судлаачдын явуулсан судалгааны үр дүнгээс үзэхэд “Хэлний орчинд нь л байвал ярианы хэлийг амархан эзэмшиж болно“ гэсэн хэвшмэл ойлголт үндэслэл муутай болохыг батлахын зэрэгцээ хэлний орчинд байсан ч ярих чадвар ахихгүй байх тохиолдол байдгийг нотолж байна. Хятадад сурч буй монгол оюутны ярих чадварын “тогтонгиших“ үзэгдлийн гол шалтгаан нь сэтгэл зүйн хүчин зүйл хийгээд монгол хүний соёлын онцлогтой холбогдож байна. Түүгээр зогсохгүй хэлний бус орчинд англи хэл сурч буй оюутан хийгээд хэлний орчинд монгол хэл сурч буй оюутны тухайд гадаад хэлний ярих чадварт сөргөөр нөлөөлж буй гол хүчин зүйл, анхаарах ёстой асуудал нь нийтлэг байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: **МОНГОЛ ОЮУТНЫ ЯПОН ХЭЛЭЭР ЯРИХ ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ**



Түүнээс гадна оюутны монгол хэлний хэрэглээний чадвар хангалтгүй байгаа нь зөвхөн монгол хэлний мэдлэг, хэрэглээний чадвар доогуур байгаатай төдийгүй тэдний ерөнхий мэдлэгийн түвшинтэй холбоотой гэж бид үзсэн. Тэдний танин мэдэхүйн хүрээ явцуу, ерөнхий мэдлэгийн түвшин доогуур байгаа нь ярих чадварт нөлөөлж байна хэмээн үзэж, урлаг, спорт, улс төр, эдийн засгийн болон өдөр тутмын энгийн сэдвүүдээр асууж судалгаа (дэлгэрэнгүйг хавсралтаас) авахад дараах дүн гарсан юм.

Монгол хэлний мэдлэг, чадвар, хэрэглээний бодит чадвар



Оюутнуудын хариулсан байдлаас авч үзвэл тэд өдөр тутам зурагтаар гардаг зүйл, хүмүүсийн ам дамжигдан яригддаг яриа, алдартай зохиолын талаарх зэрэг өдөр тутмын сэдэв голлосон мэдлэг нь 65%-с дээш хувиар дүгнэгджээ. Харин эдийн засгийн холбоотой болон урлагийн алдартан, дуурийн дуучид, спортын алдарт тамирчид, япон орны талаарх мэдлэг дунд зэрэг, бага буюу 50%-аас бага дүгнэгдсэнээс үзвэл оюутнууд мэдээллийг ихэвчлэн хүний ам дамжсан яриа, зурагт, интернетийн шар мэдээний хүрээнд л авдаг байна.

Дээрх судалгаанаас авч үзвэл оюутнууд юм юмны талаар сонссон төдий, эмх цэгц муутай замбараагүй мэдлэг, мэдээлэлтэй байгаа бөгөөд логик холбоо хамаарал бүхий нухацтай, ул суурьтай, олон талт мэдлэг хомс байгаа нь харагдаж байна. Танин мэдэхүйн хүрээ ийм хязгаарлагдмал байгаа нөхцөлд хэлний сэтгэлгээ, хийсвэр сэтгэлгээний тухай ярихад түвэгтэй юм. Энэ нь уран зохиолын ном уншихаа больсонтой нэлээд олон талаар холбоотой гэж дүгнэж байна. Ном уншихад тархинд танин мэдэхүйн өвөрмөц үйлдэл явагддаг гэж үздэг бөгөөд хэлний сэтгэлгээ задарч байдаг онцлогтой болохыг судлаачид тэмдэглэсэн байдаг.

Эх хэл ба япон хэлний ярианы чадварын харьцуулалт



Монгол хэлний чадвар, япон хэлээр ярих чадварт нөлөөлөх нь

Когнитив хэл шинжлэл, үүсгүүр хэл шинжлэлийн онолын үүднээс эх хэлний хэрэглээний чадвар доогуур байгаа нь гадаад хэлний ярианы чадварт сөргөөр нөлөөлж байна.

- Эх хэлний дүрэм төвтэй мэдлэгтэй
- Ярих чадвар нь өдөр тутмын харилцааны хүрээнд хөгжсөн
- Оюутнуудын танин мэдэхүйн хүрээ хязгаарлагдмал тул үгийн баялаг муутай
- Хэлний сэтгэлгээ төлөвшөөгүй
- Сэтгэлгээний чадвар сул

Япон хэлний дунд түвшний ярих чадварыг сонгосон шалтгаан

Түвшин	Япон хэлний мэдлэгийн шалгуур
JLPT (5 түвшин) **N-3**	*Өдөр тутмын сэдвээр тодорхой хүрээнд хүндэвтэр үг хэллэгийг хялбарчилж ойлгож чадах, ерөнхийд нь ойлгох* *Өдөр тутмын сэдвээр нэг агуулга бүхий яриаг сонсож ойлгох, хүмүүс хоорондын яриаг ерөнхийд нь ойлгох чадвар*
OPI (4 түвшин) **Дунд түвшин**	*Өөрийн хэмжээнд өгүүлбэр зохиох, амархан асуулт тавих, асуултанд хариулах зэргээр амархан яриаг өөрөө эхлүүлж, үргэлжлүүлж, дуусгаж чадна.*
JF стандарт Can-Do (6 түвшин) **Дунд түвшин**	*-ажил, сургууль, сонирхол зэрэг энгийн сэдвүүдийн хүрээнд стандарт хэллэгээр илэрхийлж буйг ойлгох* *-гадаад улсад очоод харилцаанд тулгарах асуудлыг хялбархнаар шийдвэрлэх* *-өдөр тутмын хувь хүний сонирхолд нийцэх сэдвээр, энгийн үг хэллэгээр эх зохиож чадах. Өөрийн туршлага, боломж, мөрөөдөл, хүсэлтийг тайлбарлаж санал болон төлөвлөгөө, учир шалтгааныг энгийн хэллэгээр тайлбарлаж чадах*

Сурах үйл ажиллагааны үндсэн 4 чадварын судалгаа

Монгол оюутны япон хэлээр ярих чадварыг сайжруулахад нөлөөлөх хүчин зүйл

言語ビリーフ

Хэл сурах итгэл үнэмшил

- “「言語学習ビリーフ」belief гэдэг нь суралцагчийн сурах үйлийнхээ талаар баримталж байгаа үзэл бодол, ойлголт, итгэл үнэмшлийг хэлдэг байна. (суралцагчийн хэл сурахад тохиромжтой шинж, хэл сурахад тохиолдох бэрхшээл, хэл сурахын мөн чанар, харилцааны стратеги, хэл сурах хүчин түлхэц) (Хорвиц, 1987)

第二言語不安

Хоёрдугаар хэлний айдас түгшүүр

- Хоёрдугаар хэлийг сурах, хэрэглэх, эзэмшихэд онцгойлон холбогддог айдас юмуу сэтгэл зовнил, түүнээс үүдэлтэй үүсч бий болдог биеэ барих,...үзэгдлийг хоёрдугаар хэлний айдас түгшүүр「第二言語不安」 гэнэ. (Мотода Шизү 2005)

Бид МУИС, ХИС,ШУТИС, МУБИС, МУИС-ийн Орхон сургуулийн япон хэлний ангийн нийт 246 оюутнаас япон хэлээр ярихад хэлний айдас тулгардаг эсэх талаар судалгаа авахад дунд зэрэг гэж хариулсан оюутнууд 23,5%, ер нь тулгардаг гэж хариулсан оюутнууд 53,5%-ийг эзэлж байгаа нь хэлний айдастай ямагт тулгардаг гэсэн нь харагдаж байна. Хэрэв айдас төрдөг бол юунаас үүдэлтэй вэ гэсэн асуултанд үгийн баялаг муугаас гэж 46 хувь нь хариулсан бол сэтгэл зүйн хаалт саад, биеэ барих, ичих, сандрах зэрэг сэтгэлзүйн талаас болсон гэж нийт оюутны 24% нь үзсэн байна. Мөн оюутнуудын темперамент, түгшүүрийн илрэлийг тодорхойлох зорилгоор МУИС-ОС, СЭ, МУИС, ХИС-ийн 181 оюутнаас асуулгын аргаар авсан судалгаанаас авч үзвэл тухайн оюутны темперамент, ази хүний хэв шинж, түгшүүртэй байдал /хэлний барьер/ харилцан ижил түвшинд байгаа нь харагдаж байна. Үүнийг диаграмаар харуулбал:

Оюутны темпераментийн судалгаа
, 0, 0%
аверт, 13, 25%
интроверт, 38, 75%
экстраверт
интроверт

Түгшүүрийн илрэлийн шкал
0, 0%
44, 86%
Түгшүүртэй байдлын сулхан илрэл
Түгшүүртэй байдлын дунд зэргийн илрэл
Түгшүүртэй байдлын маш хүчтэй

Гэтэл монгол оюутны энэхүү “хэлний айдас“-ын зэрэгцээ тэдэнд япон хэл заахад эерэг нөлөө бүхий сэтгэл зүйн хүчин зүйл бас байгаа юм. Энэ бол гадаад хэл сурах үйл ажиллагааны талаарх оюутнуудын хандлагын талаар монгол-япон төвийн багш Яо Юкикогийн хийсэн судалгааны үр дүн юм. Энэ бол япон хэл заах арга дахь 言語学習ビリーフ буюу “гадаад хэл сурахад өөртөө итгэх итгэл“ гэдэг хандлагын илрэлийг монгол оюутан дээр судалсан судалгаа юм. Олон орны оюутнуудтай монгол оюутныг харьцуулан авч үзсэн уг судалгаа бидэнд найдлага төрүүлж буй бөгөөд судалгааны дүнг хүснэгтээр үзүүлбэл:

Олон орны оюутнуудын өөртөө итгэх байдлын судалгаа

Улс	Судалгаанд хамрагдсан хүрээ	Тоо	Хугацаа
Монгол	Монгол-Япон төв, КТМС, “Кэса япон хэлний төв, 84-р сургууль	207	2011
Филиппин	Филиппин их сургууль	156	2003.9
Вьетнам	Ханой үндэсний их сургууль, гадаад хэлний дээд сургууль	107	2007.10
Шриланк	Кэрани их сургууль, Сабрагамва их сургууль	86	2006.5-7
Энэтхэг	Jawaharlal Nehru University, Фүнэ их сургууль, Тирак дээд сургууль	148	2010.2
Герман	Дьюссельдорф зэрэг 13 дээд сургууль	760	
Испани	Мадрид хувийн сургууль	98	2007.5
Япон	“Айчи” Боловсролын их сургууль	114	2011.5

Гадаад хэлээр суралцагсдын өөртөө итгэх итгэл

1 бүрэн санал нийлэх ⇔ 5 огт санал нийлэхгүй

№	Асуулт	Мон	Фил	Шри	Энэт	Исп	Япон
1	Хэн ч гадаад хэлийг сурч чадна.	1.6	1.5	2.5	2.2	2.8	2.1
2	Манай орны хүмүүс гадаад хэл сурахдаа мундаг.	2.0	2.3	1.8	2.2	3.8	3.7
3	Би Япон/Англи/ хэлээр маш мундаг ярьж сурна гэдэгтээ итгэл төгс байна.	2.0	2.0	1.8	1.5	2.2	3.0
4	Надад гадаад хэл сурах авьяас бий.	2.6	2.6	2.3	3.0	2.7	4.3
5	Гадаад хэлний авьяастай хүн гэж бий.	2.9	2.0	1.6	2.1	1.7	3.1
6	2-оос дээш хэл мэддэг хүнийг толгой сайтай хүн гэж боддог.	2.9		2.3	3.0		2.5
7	Гадаадаар ярьж сонсож ойлгохоос уншиж бичих нь хялбар	2.7	2.6	2.5	3.3	2.5	2.7
8	Гадаад хэлээр сонсож ойлгохоос ярих нь хялбар	2.8	2.9	3.1	3.0	3.4	3.2
9	Япон хэл/Англи/1:маш хэцүү хэл,2:Хэцүү хэл 3:Дунд зэргийн хэцүү, 4:Сурахад амар хэл、5:Сурахад маш амар хэл	3.2	2.4	3.0	2.4	2.3	3.1
10	Хэрвээ өдөрт 1 цаг гадаад хэлээр хичээллэвэл тухайн хэлээр маш сайн харилцдаг болоход хэр зэрэг хугацаа шаардагдах вэ. 1:1жилийн дотор、2:1-2жил 、3:3-5жил 、4:5-10жил 、5:өдөрт 1	3.8	2.4	2.8	3.4		3.3

Ярих чадвар эзэмшүүлэх тал дээр япон хэл заах аргад оршиж байгаа сул тал

Япон хэл заах сургалтын хөтөлбөр талаас:
-сэтгэл судлал, хэлний соёл судлал, хэл шинжлэлийн үндэслэл муутай
-орчин үеийн чиг хандлагыг тусгасан, уян хатан шинж чанартай бус
-загварчилсан бүтэцтэй
-монгол оюутны онцлогийг харгалзсан агуулга бүрхэг

Багшийн талаас:
-заах арга барил уян хатан, бүтээлч бус
-япон хэлийг монгол хэлээр заадаг
-анхан шатны түвшинд дүрэм голлож,орчуулах зарчмаар заадаг
-сурах бичиг“-ээр бус “Сурах бичиг“-ийг заах арга зонхилдог
-хэлний 4 чадварыг салангид байдлаар олгож ирсэн
-анхан шатны түвшинд дүрэм суурьтай, орчуулах аргаар заадаг

Оюутны талаас:
-хэлний бус орчинд байгаагаас шалтгаалан япон хэлээр сонсох чадвар хангалттай түвшинд хүч чадаагүй
-монгол оюутанд дорнын үндэстний соёлын онцлогтой холбоотойгоор түлхүү илэрдэг хэлний айдас, хэлний барьер буюу 言語不安
-монгол оюутны сэтгэл зүйн онцлог
-монгол оюутны ерөнхий мэдлэгийн түвшин доогуур
-монгол хэлний хэрэглээний бодит чадвар муу байгаа явдал

Монгол оюутанд (JLPT- 3түвшинд) япон хэлээр ярих чадварыг эзэмшүүлж буй өнөөгийн байдал



Монгол оюутны (JLPT- 3түвшинд) япон хэлээр ярих чадварыг сайжруулах боломж



Энэхүү судалгааны ажлын сэдвийн хүрээнд НҮБ-ийн “Тогтвортой хөгжлийн бодлого“ болон “Боловсролын илтгэл“, МУ-ын Засгийн газрын “Боловсрол“ 2010-2021 Үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлал, гадаад хүнд зориулсан япон хэлний сургалтын олон улсын жишиг хандлага зэргийг арга зүйн үндэс болгон хэлний бус орчинд, япон хэлний гадаад хүнд зориулсан түвшин тогтоох стандартын дунд (JLPT-N3) түвшинд монгол оюутны япон хэлээр ярих чадварыг сайжруулах боломжийг авч үзлээ. Судалгаанд МУИС, МУИС-ийн Орхон сургууль, ХИС, ШУТИС, МУБИС-ын япон хэлний багш, орчуулагч мэргэжлээр суралцаж буй 512 оюутан (давхардсан тоогоор), 45 багшийг хамруулан дараах судалгааг явуулсан болно.

Сэтгэл судлалын сорилын аргаар:
-Монгол оюутны темпераментийг тодорхойлох
-Монгол оюутны анхаарлын түвшинг тогтоох
-Монгол оюутны “гадаад хэл сурах итгэл үнэмшил“-ийг тогтоох
-Монгол оюутны түгшүүрийн түвшинг тогтоох
-Монгол оюутны “ хэлний айдас“-ын түвшинг тогтоох судалгааг
ЭЕШ-ын болон япон хэлний ТТШ-ын зориулалтын тест болон асуулгын аргаар:
-Монгол хэлний мэдлэг,чадварын түвшин тогтоох
-Япон хэлний дунд түвшинд хэлний 4 чадварын түвшин тогтоох
-Оюутны ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох судалгааг тус тус авсны дээр ярилцлага болон асуулгын аргаар авч дараах дүгнэлтэд хүрлээ.

ДҮГНЭЛТ

Их дээд сургуулийн мэргэжлийн ангид япон хэлээр ярих чадвар олгох сургалтын өнөөгийн нөхцөл байдлыг өөрчлөн шинэчилж чадвал монгол оюутнуудын хувьд хэлний бус орчноос үл хамааран япон хэлний дунд түвшинд ярих чадварыг нь сайжруулах бүрэн боломжтой гэж үзлээ.

Өнөөгийн япон хэлээр ярих чадвар олгох сургалтын байдлыг товч дүгнэвэл, сургалт ерөнхийдөө япон хэл заах арга болон сэтгэл судлал, хэл шинжлэл, хэлний соёл судлалын үндэс муутай, ерөнхийдөө уламжлалт арга барилаар явагдаж байгаа нь судалгаанаас харагдаж байлаа. Ялангуяа боловсрол судлалын асуудлыг “ХҮН” төвтэйгээр авч үзэх болсон шинэ чиг хандлагын хүрээнд монгол оюутны сэтгэлзүйн онцлог, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг онцгой харгалзан үзэх тал дээр сул анхаарч ирсэн болно.

ДҮГНЭЛТ

1.Сэтгэл зүйн хүчин зүйлийн талаас:

-「言語学習ビリーフ」буюу “хэл сурах итгэл үнэмшил“-ийн тал дээр бусад орны оюутнаас илүү түвшинд байгаа монгол оюутны давуу талыг ашиглах

-「言語不安」буюу япон хэлээр ярих үед үүсдэг айдас түгшүүрийг саармагжуулах элементүүдийг монгол оюутанд зориулсан япон хэлний ярианы хичээлд нэмэлтээр боловсруулан тусгаж оруулах

-Багш өөрөө судлаач байж, нийгэм, цаг үеийн өөрчлөлтийг соргогоор мэдэрсний үндсэн дээр оюутны темперамент болон хэл сурах сэтгэл зүйн онцлогийг оношлон тогтоож, түүнд тохируулан сургах арга барилыг боловсруулах

ДҮГНЭЛТ

2. *Зэрэгцүүлсэн хэл шинжлэл, түгээмэл хэл зүйн талаас:*

-L1- L2-ийн хамаарал болон стимул-реакцийн онолд тулгуурлан оюутны монгол хэлний хэрэглээний чадварын түвшинг нарийвчлан тогтоож, ярианы чадвар сайжруулах сургалтанд анхаарах

-Монгол хэл – япон хэлний харилцан хамаарлыг ярианы хэлний чадвар талаас нь судлан үзэж сургалтын агуулгад тусгахад анхаарах

ДҮГНЭЛТ

3.Япон хэл заах аргын талаас:

-Анхан шатны түвшинд дүрэм голлож, орчуулах аргаар заадаг арга барилыг өөрчилж, ярих сэдэл төрүүлэх, сэтгэл зориггүйдлээс сэргийлэх нэг элемент болох үгийн сангийн баялагтай болгох, хэлзүйн түгээмэл бүтцүүдийг эзэмшүүлэх үр дүнтэй арга болох чангаар уншуулж, текст цээжлүүлэх уламжлалт аргыг өргөн ашиглах

-共同学習 буюу хамтран суралцах аргыг монгол оюутны онцлогт тохируулан бүтээлчээр ашиглах

-JFстандартын хүрээнд Can-do арга зүйд суурилсан, бүтээлч сургалт явуулах

-Япон хэлээр ярих чадварыг сайжруулахад японд суралцаж буй гадаад оюутанд зориулсан нийтлэг сурах бичгүүдийг хэрэглэхээс илүүтэй монгол оюутны суралцах онцлог, танин мэдэхүйн хэв маяг, сэтгэхүй, соёлын онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн,гарын авлага боловсруулж хэрэглэх

ДҮГНЭЛТ

4.Хэлний соёл судлалын талаас:

-Хоёр хэлний соёл хоорондын ялгааг онцгой анхаарч, ярианы чадвар эзэмшүүлэх сургалтанд анхан шатны түвшнээс эхлэн “соёлоор нь дамжуулан хэлийг нь заах“ зарчмыг баримтлах

-Хичээлийн танхимд хэлний бичил орчин бий болгох үүднээс хичээлийг япон хэлээр заах (монгол хэл мэдэхгүй япон багшийн барилаар)

-Япон хэлний дунд түвшний ярианы чадварыг сайжруулахад бэрхшээл учруулдаг япон соёлын ялгаа, онцлогийг илэрхийлдэг голойлголтууд болох “босоо-хэвтээ харьцаа”, “хүний – өөрийн хүмүүстэй харьцах ялгаа“, “захирах захирагдах харьцаа“, “хүндэтгэлийн үгийн хэрэглээ“, “шууд бусаар тойруулан хэлэх арга“ （「縦・横　」、「内・外」、上下関係、敬語の使い方、間接話法）зэргийг хялбар аргаар эзэмшүүлэхэд анхаарах

ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА